

**ТЭЭВРИЙН ЦАГДААГИЙН АЛБАНЫ ЗАМЫН ЦАГДААГИЙН ГАЗРЫН ЧИНГЭЛТЭЙ
ДҮҮРЭГ ДЭХ ЗАМЫН ЦАГДААГИЙН ХЭЛТСИЙН 2019 ОНЫ ЭХНИЙ ХАГАС
ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2019.06.07

Улаанбаатар хот

Нэг.Удирдлага, зохион байгуулалтын талаар:

а. Монгол Улсын Их Хурал, Засгийн газар, Хууль зүй дотоод хэргийн яам болон дээд шатны байгууллагаас гаргасан хөтөлбөр, төлөвлөгөө, үүрэг, ажлын чиглэл болон холбогдох эрх зүйн баримт бичигт тусгагдсан ажил, ажил арга хэмжээний хэрэгжилтийг хангах чиглэлээр: Байгаль орчин аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн даргын 03/3169, ЦЕГ-ын дэд бөгөөд Нийслэлийн цагдаагийн газрын даргын 3а/2687, Цагдаагийн ерөнхий газрын даргын 01/891, А/49 Захиргааны удирдлагын газрын даргын 5/91, 92, 95 Төлөвлөлт зохион байгуулалтын хэлтсийн даргын 5г/1599, 2673, Хуулийн хэлтсийн даргын 5г/1661, 1841, 2147, 2399, 2580, 2581, Соён гэгээрүүлэх албаны сургалтын хэлтсийн даргын 5д/2217, 2522, Санхүү аж ахуйн албаны даргын 6/732, Нийслэлийн Засаг даргын 03 тоот албан даалгавар, Тээврийн цагдаагийн албаны даргын 14/626, 628, 675, 669, 684, 764, 837 Тээврийн цагдаагийн албаны дэд бөгөөд Захиргааны удирдлагын газрын даргын 14-1/631, 632, 637, 639, 665, 668, 685, 692, 769, 770, 803, 809, 823 Төлөвлөлт зохион байгуулалтын хэлтсийн даргын 14-1а/634, 649, 653, 695, 700, 722, 739, 751, 790, 791, 820, 826 831, 865, 880 Замын цагдаагийн газрын даргын 14-2/226, 252, 255, 266, 303 Нийслэлийн замын хөдөлгөөний хяналтын хэлтсийн даргын 14-20/266, 267, Чингэлтэй дүүргийн засаг дарга, дарга, Чингэлтэй дүүргийн онцгой байдлын хэлтсийн дарга нараас ирүүлсэн нийт 361 тушаал, шийдвэр, үүрэг, ажлын чиглэл, зөвлөмжийг алба хаагч нарт танилцуулан хэрэгжүүлэх чиглэлээр удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллаж байна.

б.Хүний нөөцийн талаар:

Тус хэлтэс нийт 56 алба хаагчийн орон тоотой Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн хэрэг ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор хяналт шалгалт, замын хөдөлгөөнийг зохицуулах үйл ажиллагааг өдөр тутам явуулан ажиллаж байна.

Хэлтсийн 56 алба хаагчаас ээлжийн амралттай 7, сургуулийн чөлөөтэй 1, цагдаа зохицуулагчийн 3 орон тоо дутуу, гудамж замын хяналт шалгалтад нийт 36 алба хаагч 8 автомашинтайгаар үүрэг гүйцэтгэж ажилласан.

**в. Байгууллагын үйл ажиллагаа түүнийг сайжруулах
чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээ:**

Чингэлтэй дүүрэг дэх замын цагдаагийн хэлтэс нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зам тээврийн осол хэргийг бууруулах чиглэлээр холбогдох хууль, тушаал, шийдвэрүүдийг биелүүлэх, цаг үеийн мэдээ мэдээллийг хэлтсийн бие бүрэлдэхүүнд долоо хоног бүрийн Даваа, Пүрэв гаригийн хэлтсийн хурлаар танилцуулж, хэвшсэн. Долоо хоног бүрийн Даваа гаригт хийдэг офицеруудын хурлыг Сахилгын хурал болгож, хурлаар алба хаагчдын ажлын амжилт, мөн гарч буй алдаа дутагдлын талаар хэлэлцэн сайн ажиллаж байгаа алба хаагчдыг урамшуулах, ажлын алдаа дутагдал гаргасан алба хаагчдыг дахин зөрчил дутагдал гаргуулахгүй байх талаар анхааруулж ажлын үр дүнг тооцон удирдан зохион байгуулан ажиллаж байна.

Алба хаагчдын ажлын ачааллыг тэнцвэржүүлэх үүднээс ачаалалтай уулзваруудад /пост/ алба хаагчдыг 7 хоногоор тойруулан жигд байдлаар ажиллуулж байна. Мөн бүс хариуцсан зохицуулагч нар гудамж замд үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдыг албаны автомашинд тодорхой хугацаагаар суулгаж хөлийг нь амраах, цай, хоолонд орох үед нь хариуцсан постыг хяналтад авах зэрэг ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

ЦЕГ-ын даргын 2015 оны А/87 тоот тушаалын дагуу бүртгэл судалгааны 4 төрлийн дэвтэр, хэлтэст хөтлөгдвөл зохих 13 төрлийн бүртгэл судалгааны дэвтэр, алба хаагчдын 7 хоногийн төлөвлөгөө болон өврийн дэвтрүүдийг хэлтэс дотооддоо зохион байгуулан хэвлүүлж албаны үйл ажиллагаанд ашиглаж байна.

Хэлтсийн офицер алба хаагчдын 2018 оны хөрөнгө орлогын мэдүүлгийг бөглүүлж ТЦА-ны Хүний нөөцийн ахлах мэргэжилтэнтэй тулгасан.

Хэлтсийн даргаас 2018 онд алба хаагчидтай байгуулсан үр дүнгийн гэрээг үнэлж дүгнэсэн илтгэх хуудсыг хурлын тэмдэглэлийн хамт ТЦА-ны ЗУХ-т хүлээлгэн өгсөн.

ТЦА-ны 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу хэлтсийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж НЗХХХ-ийн даргаар, 1, 2-р улирлын үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж хэлтсийн даргаар тус тус батлуулж биелэлт үр дүнг заасан хугацаанд тооцон ажиллаж байна.

Тээврийн цагдаагийн албаны Замын цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа Д.Дашдоржтой алба хаагчид 2019 онд “Итгэлцлийн гэрээ”-г байгуулсан.

Хэлтэс хамт олны зургийг 2019 оны байдлаар авхуулж, хамт олны зургийн цомгийг хэлтсийн байранд байрлуулсан.

Сар шинийн баяртай холбогдуулж хэлтэст ашиглагддаг албаны 8 автомашины техникийн бүрэн бүтэн байдлыг хэлтэс дотооддоо 2019 оны 01 сарын 26, 27-ны өдөр шалгаж, заагдсан зөрчлийг арилгасан танилцуулгыг Замын цагдаагийн газрын даргад хүргүүлсэн.

Чингэлтэй дүүргийн хороодтой 2019 онд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр зохицуулагч хамтран ажиллах гэрээ байгуулсан.

Энэ оны 03 дугаар сарын 13-ны өдөр Тээврийн цагдаагийн албаны архивд архивын материалыг эмхэтгэж дуусган хүлээлгэн өгсөн.

Ахлах хэрэг бүртгэгч цагдаагийн дэд хурандаа И.Шагдарсүрэнд хэлтсийн даргаас зөрчлийн хэрэг бүртгэлт, хэлтсийн дотоод ажилтай холбоотой өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдөж ажиллах зааварчилгаа өгч, баталгаа гаргуулан авсан.

Албаны бэлэн байдлыг хангах үүднээс 2019 оны 01 дүгээр сард 2 удаа, 2019 оны 02 дугаар сарын 21-ний өдөр 06:00 цагт хэлтсийн байрны гадна талбайд жагсаалын үзлэг, 2019 оны 03 дугаар сарын 11-ний өдөр 05:30 цагт, Цагдаагийн ерөнхий газрын дэд даргын 01 дугаар тушаалаар Улаанбаатар цагдаагийн хүрээний офицер, ахлагч бүрэлдэхүүнийг 2019 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс зуны хувцсанд шилжих тушаалын хүрээнд тус хэлтсээс 2019 оны 04 сарын 02-ны өглөө 06:30 цагт, ТЦА-с 2019 оны 04 сарын 09-ны өглөө 05:30 цагт ЦС-111 дохиогоор Цагдаа хөшөөн дээр зарласан түргэн цугларалт, Нийслэлийн нутаг дэвсгэрт гарч болзошгүй гамшиг осол тохиолдсон үед замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах хамгаалалтад ажиллах алба хаагчдыг 2019 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 05 цагт хэлтсийн байранд тус тус зохион явуулсан жагсаалын үзлэгт алба хаагчид зөрчил дутагдал заагдаагүй болно.

Чиглэлийн ахлах зохицуулагч ЦЕГ-ын даргын 2015 оны А/87 тоот тушаалын дагуу зохицуулагч нарын бүртгэл судалгаа хийсэн байдалтай танилцаж, үнэлэлт дүгнэлт өгч, албаны даргын баталсан удирдамжийн дагуу Төлөвлөлт зохион байгуулалтын хэлтсийн даргаар ахлуулсан ажлын хэсэгт хэлтэст хөтлөгдөж байгаа бичиг хэрэг, хэрэг бүртгэлтийн үйл ажиллагаа, А/87 тоот тушаалын дагуу зохицуулагч нарын бүртгэл судалгааг 2019 оны 03 дугаар сарын 15-ны өдөр шалгуулсан.

Дүүргийн нутаг дэвсгэрт “Согтуу” хэсэгчилсэн арга хэмжээг батлагдсан хуваарийн дагуу 8 удаа зохион байгуулан ажилласан.

Дахин дамжуулагч Хүрэмт-40 постын орчимд байсныг төвийн гудамж замд үүрэг гүйцэтгэж байгаа постууд хоорондоо холбогдоход хүндрэлтэй байгаа тул дахин дамжуулагчийг наашлуулан “Primum palace”-ийн дээвэр дээр байрлуулах ажлыг зохион байгуулсан.

Энгэрийн камерын бичлэгийг хэрхэн хуулуулах талаар чиглэлийн ахлах зохицуулагч, цагдаагийн хошууч Ц.Чинзоригоос алба хаагч нарт 1 удаагийн зааварчилгаа өгч гарын

үсгээр баталгаажуулж, камерын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор камерын бичлэгийг цаг тухай бүрд нь хуулуулаагүй алба хаагчдын цалинг 2019 оны 02, 03, 04-р сард нийт 4 алба хаагчийн үндсэн цалинг тус бүр 5 хувиар хассан. Мөн камерын бичлэгийг тогтмол заасан хугацаанд өгч хуулуулсан 2 алба хаагчийн цалинг 2019 оны 02, 04-р сард тус бүр 10 хувиар нэмж урамшуулсан.

Хэлтсийн 15 алба хаагчийн согтуурал шалгадаг тандагч багажийн мэдрэгч эвдэрснийг ТЦА-с шинээр сольж өгсөн.

Хэлтсийн алба хаагчид бэлэн байдлын үед цуглах түргэн цугларалтын схемийг 2019 оны 03 сарын 29-ний байдлаар шинэчилсэн.

ЦЕГ-н Авто баазаас албаны үйл ажиллагаанд ашиглахаар Н.Асцент маркийн 6201унү улсын дугаартай автомашиныг шинээр авч, гүйлт нормын хугацаа дууссан Н.Асцент маркийн 0229унү улсын дугаартай автомашиныг хүлээлгэн өгсөн.

Албаны K.Rio маркийн 0651унү усын дугаартай авто машины урд салхины шил тодорхойгүй шалтгаанаар цуурсныг тухайн автомашины хариуцсан бүсийн офицерууд шинээр сольсон.

Албаны бэлэн байдлыг сайжруулах зорилгоор алба хаагчдын аранзыг жигдрүүлэх ажлыг 2019 оны 04 дүгээр сард зохион байгуулсан.

Тус хэлтэст ашиглагддаг зөөврийн постын үйл ажиллагааг сайжруулах үүднээс постын гадна талыг угааж police бичиглэлийг шинээр сольж, дотор талыг угааж цэвэрлэж, ЦЕГ, ТЦА-аас зохион байгуулсан нээлттэй хаалганы өдөрлөгт албаны техник, хэрэгслийг игэд, олон нийтэд сурталчилж ажилласан.

Тээврийн цагдаагийн албанаас ахлах мэргэжилтэн П.Норовсамбуугаар ахлуулсан ажлын хэсэг хэлтсийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг 2019 оны 06 дугаар сарын 05-ны өдөр, аж ахуйн тасгаас хэлтсийн эд аж ахуй, техник хэрэгслийн тооллогыг 2019 оны 06 дугаар сарын 06-ны өдөр тус тус шалгасан.

г. Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд хийсэн ажил, арга хэмжээ:

Тус хэлтсийн ахлах хэрэг бүртгэгч шинээр томилогдсонтой холбоотойгоор 2019 оны 01 сарын 14-ний өдөр Чингэлтэй дүүргийн прокурорын газрын зөрчил хариуцсан ахлах прокурор А.Алиманцэцэг, Замын цагдаагийн хэлтэс хариуцсан прокурор Д.Дэлгэрмаа нар өнгөрсөн оны үлдэгдэл хэргийг яаралтай шахаж дуусгах, ахлах хэрэг бүртгэгч, цагдаагийн дэд хурандаа И.Шагдарсүрэнд хийж гүйцэтгэх ажлын зөвлөгөө өгсөн.

Ахлах хэрэг бүртгэгч цагдаагийн дэд хурандаа И.Шагдарсүрэн зохицуулагч нарын хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн зам тээврийн ослын материалын бүдүүвч зураг, торгуулийн шийтгэврийн хуудасны биелэлтийг хангуулсан талаар үзэж шалгасан.

Дүүргийн нутаг дэвсгэрт гарсан зам тээврийн хэрэг, осолд дүн шинжилгээ хийж, шалтгаан нөхцөлийн судалгааг ахлах хэрэг бүртгэгч 7 хоног бүр албаны даргад танилцуулж байна.

д. Төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажилласан тухай:

Чингэлтэй дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтарч 1-19 дүгээр хороод 2018 онд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ажлыг шалгасан.

Тус хэлтсээс 2018 онд хийж хэрэгжүүлсэн ажлаа дүүргийн иргэдэд тайлагнаж, тэдний санал хүсэлтийг сонсож хийсэн ажлаа дүгнүүллээ.

“Сар шинэ 2019” нэгдсэн арга хэмжээний хүрээнд Чингэлтэй дүүргийн цагдаагийн 1, 2 дугаар хэлтэстэй гэмт, хэрэг, зөрчил илрүүлэх, урьдчилан сэргийлэх, хяналт шалгалт зохион байгуулах чиглэлээр хамтран ажиллах төлөвлөгөөг боловсруулж хэлтсийн дарга нараар батлуулан, хэрэгжилтийг ханган үр дүнг тооцон ажилласан.

Сар шинийн баяртай холбогдуулж цагдаагийн 2 дугаар хэлтсээс 1 автомашинтай 2 алба хаагч, тус хэлтсээс 1 автомашинтай 3 алба хаагчийг “Хүчит шонхор”, “Нарантуул-2” худалдааны төв орчмоор хяналт шалгалт болон хөдөлгөөн зохицуулан ажилласан.

Сар шинийн баяртай холбогдуулан замын хөдөлгөөний ачаалал, түгжрэл саатал ихсэж байгаатай холбогдуулан Автозамын хөгжлийн газар, Хүчит шонхор, Нарантуул-2, Бөмбөгөр, Улсын их дэлгүүр, Тэди төв, Алтжин бөмбөгөр худалдааны төвүүдэд хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах ажилтныг ажиллуулах талаар албан мэдэгдэл хүргүүлж, хамтран ажилласан.

Тээврийн цагдаагийн албаны 2019 оны “Цасны баяр”-ын арга хэмжээнд хэлтэс хамт олон амжилттай оролцсон.

Засгийн газрын авто баазын 57 жолооч ажилтанд шинэчлэн батлагдсан замын хөдөлгөөний дүрмээр 1:30 цагийн сургалт орсон. Фм-99.3-р шинэчлэн батлагдсан замын хөдөлгөөний дүрмээр аудио текст бэлтгэн өдөрт 10-с доошгүй удаа олон нийтэд мэдээ мэдээлэл хүргэж ажиллаж байна.

Замын хөдөлгөөний дүрэм шинэчлэн найруулсантай холбоотойгоор дүрмийн номыг иргэдэд олгож, тэдний хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор Чингэлтэй дүүргийн Засаг даргын тамгын газарт “Замын хөдөлгөөний дүрэм”-ийн ном олгож өгөхийг хүссэн тоотыг хүргүүлээд байна.

Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс Замын хөдөлгөөний шинэчилсэн дүрмийн 50 ширхэг номыг алба хаагч нарт үнэгүй олгосон.

Дүүргийн засаг даргын захирамжийн дагуу дүүргийн орлогч даргаар ахлуулсан Монгол улсын Засгийн газраас 2019 оныг “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил” нийслэлийн төр захиргааны байгууллагаас Иргэдийн оролцоотой хөгжлийн жил, дүүргийн төр захиргааны байгууллагаас Иргэдийнхээ хөгжлийг дэмжих болгон зарласантай холбогдуулан төрийн үйлчилгээг иргэдэд тэгш хүртээмжтэй, түргэн шуурхай, ил тод, нээлттэй хүргэх үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилгоор иргэдийн оролцоог хангаж иргэдийн санал хүсэлтийг сонсож шийдвэрлэх чиглэлээр 3 сарын 29-өөс 04 сарын 06-ны өдөр хүртэл Чингэлтэй дүүргийн 6-р хороонд, 04 сарын 8-аас 04 сарын 15-ны өдөр хүртэл Чингэлтэй дүүргийн 3-р хороонд уг аяны хүрээнд хуваарийн дагуу өглөө 09:00-12:00 цаг, орой 14:00-17:00 цагийн хооронд иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч ажилласан. Чингэлтэй дүүргийн 5-р хороонд уг аяныг эхэлсэнтэй холбогдуулан 04 сарын 16-өөс 4 сарын 23-ны өдөр хүртэл хуваарийн дагуу өглөө 09:00-12:00 цаг, орой 14:00-17:00 цагийн хооронд иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч ажилласан.

Цагдаа, олон нийтийн хамтын ажиллагааг сайжруулах, иргэдийн ая тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр хэлтсийн зохицуулагч нар хариуцсан хороодтойгоо 2019 онд хамтран ажиллах гэрээг байгуулан гэрээний дагуу хамтран ажиллаж байна.

Цагдаагийн алба хаагчийн хяналт шалгалт төдийлөн хүрч чадахгүй байгаа гудамж замуудад замын хөдөлгөөний дүрэм зөрчиж байгаа жолооч нарын зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох зорилгоор зохицуулагч нар өөрийн хариуцсан хорооны нийтийн болон урамшуулалт эргүүлүүдийн гар утсанд E-police апплейкшиныг суулгах ажлыг зохион байгуулласан.

Тус хэлтсээс сургууль хариуцсан зохицуулагч, цэцэрлэг хариуцсан цагдаа зохицуулагч нар дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг ерөнхий боловсролын 19 сургууль, 56 цэцэрлэгт хүүхдийг зам тээврийн хэрэг, осолд өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр хариуцсан сургууль, цэцэрлэгийн хүүхдүүд, багш ажилчид, эцэг эх, асран хамгаалагч нарын дунд 2019 оны 02 дугаар сарын 25-наас 03 сарын 15-ны хооронд бага насны хүүхдийг замын хөдөлгөөнд хэрхэн зөв оролцуулах дадал эзэмшүүлэх, хүүхдийг зам тээврийн осолд өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр эцэг эх, асран хамгаалагч, боловсролын байгууллагын ажилтан нарын үүрэг, оролцоо сэдвүүдээр 27 цагийн сургалт зохион байгуулж, сургалтад 4352 хүүхэд, эцэг эх, боловсролын байгууллагын ажилтан хамрагдаад байна. Мөн Чингэлтэй дүүргийн боловсролын хэлтэс, Цагдаагийн 2-р хэлтэс, Гэр бүл хүүхэд залуучуудын төв, Дэлхийн Зөн Монгол олон улсын байгууллагатай хамтран “Хүүхдийг зодож шийтгэхийн эсрэг хамтдаа” өртөөлсөн сургалтыг 2019 оны 04 сарын 16-аас 21-ний хооронд ерөнхий боловсролын 17, 37, 49, 57, 72, 117-р

сургуулиудын 681 хүүхдэд замын хөдөлгөөнд хэрхэн зөв аюулгүй оролцох талаар 12 цагийн сургалтыг зохион байгуулсан.

Нийслэлийн нутаг дэвсгэрт гарч болзошгүй гамшиг осол тохиолдсон үед ажиллах иж бүрэн дадлага, сургуулилтын үеэр дүүргийн онцгой комиссын дарга, гишүүд болон холбогдох 12 анги байгууллагын 256 алба хаагч нартай хамтран ажилласан. Дадлага сургуулилтыг газар хөдөлсний улмаас Засгийн газрын 11 дүгээр байр нурсан өгөгдлийн хүрээнд зохион байгуулсан бөгөөд тус хэлтсийн алба хаагч нар замын хөдөлгөөн зохицуулах бусад анги байгууллагад дэмжлэг үзүүлэх чиг үүрэгтэйгээр оролцсон.

Тус хэлтсээс Чингэлтэй дүүргийн Прокурорын газартай хамтран хэрэг бүртгэлт, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа, түүнтэй холбоотой зөрчил, дутагдлыг арилгах талаар зөвлөгөөнийг 2019 оны 05-р сард зохион байгуулсан.

2019 оны эхний ээлжийн цэрэг татлагын хамгаалалт зохицуулалтад 2019 оны 05 дугаар сарын 03, 04, 05-ны өдрүүдэд 2 алба хаагч 1 автомашинтай ажилласан.

Цагдаагийн 1, 2 дугаар хэлтэстэй хамтран дүүргийн хэмжээнд зохион байгуулсан “Автомашин-2019” нэгдсэн арга хэмжээг дүгнэж үр дүнг тооцсон.

Чингэлтэй дүүргийн ерөнхий боловсролын 5 болон 50-р сургуулийн хүүхдүүд энэ оны 4 дүгээр сард осолд өртөж хохирсонтой холбогдуулан тус сургуулиудад зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр ажил, арга хэмжээ зохион байгуулах талаар хугацаатай албан мэдэгдэл өгч, мэдэгдлийн дагуу зохион байгуулсан ажлын танилцуулгыг заасан хугацаанд авч ажилласан.

Чингэлтэй дүүргийн Боловсролын хэлтэс, Цагдаагийн 2-р хэлтэс, Хүүхэд гэр бүл хөгжлийн төв, Дэлхийн Зөн Монгол олон улсын байгууллагатай хамтран “Хүүхэд бүрт хүргэх 5 чухал амжилт” гарын авлагыг 2000 ширхгийг хэвлүүлж ерөнхий боловсролын 39, 37, 57, 17, 117, 49, 72, 61-р сургуулийн 7-р ангийн сурагчдад тараасан.

Чингэлтэй дүүргээс зохион байгуулсан “Бид сайн сайханд дагуулна” уриан доор зохион байгуулагдсан Чингэлтэй фестиваль нээлттэй хаалганы өдөрлөгт албанд ашигладаг техник хэрэгсэл болон албаны үйл ажиллагааг сурталчилж иргэд олон нийтэд Цагдаагийн байгууллагаас гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийж хэрэгжүүлж байгаа ажил, цаашид хийж хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа ажлын талаар иргэд олон нийтэд танилцуулж, зам тээврийн хэрэг ослоос урьдчилан сэргийлэх самбар, албаны техник тусгай хэрэгсэл, мотоцикл, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр бэлтгэсэн гарын авлага, боршур, наалт зэрэг нийт 5 төрлийн 850 ширхэг тараах материал гарын авлагыг иргэдэд тарааж, явуулын постыг танилцуулж ажилласан.

Тээврийн цагдаагийн албанаас зохион байгуулж байгаа “Бяцхан зорчигч” нэгдсэн арга хэмжээний хүрээнд тус хэлтсээс дүүргийн ГХУСАЗСЗ-тэй хамтран дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй төрийн болон төрийн төрийн бус байгууллага, иргэн, аж ахуй нэгж байгууллага, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, эцэг эхийн төлөөллийг оролцуулан хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх “Хүүхдээ хамгаалъя” сэдэвт хэлэлцүүлгийг 2019 оны 05 сарын 28-ны өдөр зохион байгууллаа. Тус арга хэмжээг MN-25, C-1, Eagle, Tv-6 телевизүүдийн мэдээллийн хөтөлбөрөөр арга хэмжээний талаар болон хэлэлцүүлэг нь хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, эцэг, эх боловсролын байгууллагын үүрэг оролцооны талаар иргэд олон нийтэд мэдээ, мэдээлэл өгсөн.

Ерөнхий боловсролын 49-р сургууль дээр хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг угтаж Чингэлтэй дүүргийн 13 дугаар хороотой хамтарч “Аз жаргалтай хүүхэд нас” өдөрлөгийг зохион байгуулж, өдөрлөгт хамрагдсан 6-р ангийн 156 хүүхдэд замын хөдөлгөөнд хэрхэн зөв аюулгүй оролцох талаар 1 цагийн сургалтыг зохион байгуулсан.

Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтсийн алба хаагчдад 2019 оны 05 дугаар сард замын хөдөлгөөний дүрмээр 1 цагийн сургалтыг зохион байгуулсан. Тус сургалтад Онцгой байдлын хэлтсийн 34 алба хаагч хамрагдсан.

е. Байгууллагын удирдлагад хандаж ирүүлсэн өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн талаар:

Засгийн газрын 11-11 төвд иргэд, байгууллагаас Чингэлтэй дүүрэг дэх замын цагдаагийн хэлтсийн үйл ажиллагаатай холбоотой ирүүлсэн 19, зам тээврийн ослын 11 буюу нийт 30 өргөдөл гомдлыг хүлээн авч заасан хугацаанд шийдвэрлэж, өргөдөл гаргасан иргэн, албан тушаалтанд хэрхэн шийдвэрлэсэн талаар танилцуулан ажилласан.

ё. Нэвтрүүлсэн шинэлэг ажил, арга хэмжээ:

Хэлтсийн удирдлагуудын зүгээс тус хэлтэст ажиллаж байсан үе үеийн ахмад ажилтан, одоо ажиллаж байгаа алба хаагчдын дүрийг мөнхжүүлэх зорилгоор зургийн цомогтой болох ажлын хүрээнд хэлтэс хамт олны зургийг 2019 оны байдлаар авхуулж жаазлан хэлтсийн байранд, ЦЕГ, ТЦА-ны 2019 оны зорилтыг алба хаагчдын өрөөнд байрлуулсан.

Тээврийн цагдаагийн албанаас зохион байгуулсан ахмадын золголтын арга хэмжээнд хэлтэст харьяалагддаг 18 ахмад ажилтныг хамруулж, нэгдсэн нэг унаагаар үйлчилсэн.

Цагдаа, олон нийтийн хамтын ажиллагааг сайжруулах, иргэдийн ая тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр хэлтсийн зохицуулагч нар хариуцсан хороодтойгоо 2019 онд хамтран ажиллах гэрээг чиглэлийн ахлах зохицуулагч, ахлах зохицуулагч, ахлах хэрэг бүртгэгч, ажил хариуцсан мэргэжилтэн нартай хамтран байгуулсан.

Шинийн 3-нд Чингэлтэй хайрханд гарч өглөөний нар харах, хайрхан дээр хэлтсийн золголтыг зохион байгуулсан.

Тус хэлтсээс 2019 он гараад дүүргийн хэмжээнд гарсан зам тээврийн хэрэг, ослын судалгааг хүн амь нас хохирсон, гэмтсэн, хүүхэд өртөж хохирсон болон хэрэг, осол гарсан байршил, гариг, цагийг өмнөх оны мөн үетэй харьцуулсан байдлаар сар, улирал, эхний хагас жилээр гаргаад байна. Дээрх хар цэгийн судалгаанд тулгуурлан хяналт шалгалтыг зохион байгуулж зам тээврийн хэрэг осол ихээр гардаг цэгүүдэд хяналт шалгалтыг явуулснаар гарч болзошгүй хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх, бууруулах үр дүнтэй арга хэмжээ болж байна.

Тус хэлтсээс ТЦА-ны Жижүүрийн шуурхай хэлтсээс эрэн сурвалжилж зарлан мэдээлсэн тээврийн хэрэгслийн илрэлтийг сайжруулах зорилгоор 2 цаг тутамд алба хаагчдад зарлан мэдээлж, зарлагдсан дугаарын илрүүлэлтийг сайжруулан ажиллаж байна.

Албанд ашиглагдаж байгаа автомашинуудын гадна талын лого, түлхүүрийн оосрыг шинээр сольсон.

Тус хэлтэст албаны үйлчилгээнд ашигладаг К.Рио маркийн 0641унү, К.Рио маркийн 0651унү улсын дугаартай автомашинуудын урд талын гэрлийн цайрын өнгө үзэмж муудсаныг бүсийн зохицуулагч нар шинээр сольсон.

Алба хаагчид зөрчил илрүүлэх үедээ энгэрийн камерын бичлэг хийх, хийсэн бичлэгийг хэрхэн хуулбарлан хадгалах тухай зааварчилгаа өгсний дагуу алба хаагч бүр өдөр тутам камерын бичлэгийг хийж, хуулбарлуулж хэвшсэн.

Тус хэлтэст албаны үйлчилгээнд ашигладаг К.Рио маркийн 0641унү улсын дугаартай автомашины моторын эвдрэлийг ЦЕГ-н Авто баазын засварын хэсэгт засуулж, хэвийн ажиллагаанд оруулсан.

Тээврийн цагдаагийн албанй 2019 оны “Соёлч байгууллага” аяны хүрээнд тус хэлтсээс “Бид чадна” 1 сарын хугацаатай төлөвлөгөөг боловсруулан, төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх ажил, арга хэмжээг хариуцсан алба хаагчид зохион байгуулан ажиллаж байгаа бөгөөд үр дүнг 2019 оны 06 дугаар сарын 17-ны өдөр дүгнэхээр төлөвлөн ажиллаж байна.

Тус хэлтэст 2019 он гараад хэрэг бүртгэгч, зохицуулагч нарын шалгаж шийдвэрлэсэн зөрчлийн шийтгэврийн биелэлтийг хангуулах ажлыг зохион байгуулж байна.

Тус хэлтсээс “Бяцхан зорчигч” нэгдсэн арга хэмжээний хүрээнд зам тээврийн осолд өртөж хохирсон хүүхдүүдэд туслах зорилгоор цус хандивлах аяныг зохион байгуулж, алба

хаагчид 2019 оны 05 дугаар сарын 24-ний өдөр Цус сэлбэлт үндэсний төвд цусаа хандивласан.

Тус хэлтэст ашиглагддаг зөөврийн постын үйл ажиллагааг сайжруулах үүднээс постын гадна талыг угааж police бичиглэлийг шинээр сольж, дотор талыг угааж цэвэрлэж, ЦЕГ, ТЦА-аас зохион байгуулсан нээлттэй хаалганы өдөрлөгт албаны техник, хэрэгслийг игэд, олон нийтэд сурталчилж ажилласан.

Албаны үйл ажиллагааг сайжруулах зорилгоор албаны 8 автомашиныг дүүргийн нутаг дэвсгэрт тодорхой цэгт ажиллуулж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ухуулга сурталчилгаа хийлгэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

ж. Судалгаа дүн шинжилгээ хийсэн ажлын талаар:

Замын цагдаагийн газрын даргын өгсөн үүрэг, ажлын чиглэлийн дагуу олон нийтийн цагдаа нарын амьдарч буй нөхцөл байдал болон гэр бүлийнхэнтэй биечлэн уулзаж, тэдний санал хүсэлтийг хүлээн авах зорилгоор ар гэрээр орох ажлыг зохион байгуулсан.

ЦЕГ-ын даргын 2016 оны А/87 дугаар тушаалын бүртгэл судалгааны маягтын дагуу дүүргийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг болон авто засварын газрын дэлгэрэнгүй судалгааг шинэчлэн баяжуулсан.

Тус хэлтсээс 2019 он гараад дүүргийн хэмжээнд гарсан зам тээврийн хэрэг, ослын судалгааг хүн амь нас хохирсон, гэмтсэн, хүүхэд өртөж хохирсон болон хэрэг, осол гарсан байршил, гариг, цагийг өмнөх оны мөн үетэй харьцуулсан байдлаар сар, улирал, эхний хагас жилээр гаргаад байна. Дээрх хар цэгийн судалгаанд тулгуурлан хяналт шалгалтыг зохион байгуулж зам тээврийн хэрэг осол ихээр гардаг цэгүүдэд хяналт шалгалтыг явуулснаар гарч болзошгүй хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх, бууруулах үр дүнтэй арга хэмжээ болж байна.

Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр “Сар шинэ 2019”, “Хулгай”, “Хаалт боолт”, “Дүүрэг”, “Хурд”, “Тусгай дуут дохио”, “Гэрэлтүүлэх хэрэгсэл”, “Мотоцикл”, “Ачааны автомашин”, “Автомашин-2019”, “Согтуу”, “Улсын дугаар”, “Бяцхан зорчигч” зэрэг нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг дүүргийн нутаг дэвсгэрт хяналт шалгалтыг эрчимжүүлэн Асап санд эрэн сурвалжлагдаж байсан 69 иргэн, цагдаагийн нийтлэг үүргээр 56 зөрчлийг тус тус илрүүлж холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэн ажиллаж байна.

Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт 2018 онд хүний амь нас эрсэдсэн зам тээврийн хэргийн шалтгаан нөхцөлийн судалгааг гаргаж, цаашид хүний амь нас эрсэдсэн зам тээврийн хэргийг бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гаргаж, төлөвлөгөөний дагуу ажил арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна.

Тус хэлтсээс дүүргийн ГХУСАЗСЗ-тэй хамтран дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй төрийн болон төрийн төрийн бус байгууллага, иргэн, аж ахуй нэгж байгууллага, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, эцэг эхийн төлөөллийг оролцуулан зохион байгуулсан хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх “Хүүхдээ хамгаалъя” сэдэвт хэлэлцүүлгийн хүрээнд 2019 оны эхний 4 сарын байдлаар дүүргийн нутаг дэвсгэрт хүүхэд өртсөн зам тээврийн ослын судалгааг өмнөх оны мөн үетэй харьцуулсан байдлаар гаргаж, хэрэг ослын нөхцөл байдлын талаар танилцуулж, цаашид хүүдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх зохион байгуулах ажлын санал, хүсэлтийг хүлээн авч саналыг хэрэгжүүлэх чиглэлээр хийх ажлыг тодорхой үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

з. Бусад:

Чингэлтэй дүүргийн прокурорын газраас 2019 оны 3 сарын 19-ны өдрийн 6/836 албан бичгээр дотооддоо бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах үүрэг чиглэл өгсний

дагуу 2019 оны 04 сарын 01-ны өдөр 14-2н/124 албан бичгээр зөрчлийг арилгуулсан талаар хариуг хүргүүлсэн.

Тээврийн цагдаагийн албаны I-р улирлын сахилгын зөвлөгөөнд алба хаагчийг хамруулсан.

Нийслэлийн тээврийн газрын 50 жилийн ойг тохиолдуулан авто тээврийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагуудын ажилтан алба хаагч нарын дунд зохион явуулж байгаа “Хотын тээврийн хөгжлийн чиг хандлага” сэдэвт илтгэлийн уралдаанд зохицуулагч, цагдаагийн ахмад Б.Сэргэлэнбаатар, Дотоод хэргийн их сургуулиас зохион байгуулж буй “Цагдаагийн байгууллагын ахлагч бүрэлдэхүүнд тулгамдаж буй асуудал, түүнээс гарах арга зам” сэдэвт илтгэлийн уралдаанд цагдаа зохицуулагч цагдаагийн ахлагч М.Булганаа нар хэлэлцүүлэгт тус тус материалаа өгсөн.

Замын хөдөлгөөний түгжрэл саатлыг бууруулах, зам тээврийн хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор Чингэлтэй дүүрэг 6-р хороо Баянбүрдийн тойргийн хөдөлгөөн зохион байгуулалтад өөрчлөлт оруулах, 3-р хороо Тэди төвийн зүүн талын орц, гарцад өөрчлөлт оруулсан талаарх танилцуулгыг Нийслэлийн замын хөдөлгөөний хяналтын хэлтсийн даргад танилцуулж, Тэди төвийн зогсоолын талбайн орц, гарцын хөдөлгөөн зохион байгуулалтыг өөрчилсөн.

Төрийн албан хаагчийн анкет шинэчлэгдсэнтэй холбогдуулан тус хэлтсийн алба хаагчдын төрийн албан хаагчийн анкетыг шинэчлэн ТЦА-ны Хүний нөөцөд хүргүүлсэн.

ЦЕГ-н Apple программаар нийт 8 үүрэг, ажлын чиглэл ирсний дагуу тухай бүрд хийж хэрэгжүүлсэн ажил арга хэмжээний талаар хариуг өгч ажиллаж байна.

Алба хаагчид зөрчил илрүүлэх үедээ энгэрийн камерын бичлэг хийх, хийсэн бичлэгийг хэрхэн хуулбарлан хадгалах тухай зааварчилгаа өгсний дагуу алба хаагч бүр өдөр тутам камерын бичлэгийг хийж, хуулбарлуулж хэвшсэн.

Тээврийн цагдаагийн албанаас ахмад ажилчдыг Бугатын сангийн аж ахуйд амруулах ажлыг зохион байгуулсантай холбогдуулж тус хэлтсээс 1 алба хаагч 1 автобустай үйлчилсэн.

Нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүсэх үеийн замын хөдөлгөөнийг хаах 2 ачигч автомашины бэлэн байдлын гэрээг шинэчилсэн.

Дүүргийн гамшгаас хамгаалах дадлага сургалтыг 2019 оны 04 сарын 09-ны 07:00-12:00 цагийн хооронд Тусгаар тогтнолын талбайд зохион байгуулсан. Үүнтэй холбогдуулан Лааганы гудамжны замын хөдөлгөөнийг түр хугацаагаар хааж хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган ажилласан.

Чингэлтэй дүүргийн хөдөлгөөн зохицуулах албаны гамшгаас хамгаалах төлөвлөгөөг шинээр хийж хэлтсийн дарга болон дүүргийн Онцгой байдлын хэлтсийн орлогчоор батлуулсан.

Олон нийтийн цагдаагаар ажиллах хүсэлтэй 3 иргэнийг судалж, материалыг Хүний нөөцийн тасагт 2019 оны 05 сард хүргүүлсэн.

ЦЕГ-ын Авио бааз дээр Kia Рио маркийн 06-40 УНУ улсын дугаартай автомашины рулын аппарат, наклад солиулах ажлыг зохион байгуулж байна.

Хамгаалах бүсний хэрэглээг сайжруулах зорилгоор Хүчит шонхор зах орчим Хүрэмт-13 бүсийн эргүүлтэй хамтран хяналт шалгалт хийж хамгаалах бүс бүслээгүй жолооч нарт хариуцлага тооцон, бүсээ бүсэлсэн 50-н жолоочийг урамшуулж санамж, утасны дугаар бичдэг наалт өгсөн.

Чиглэлийн ахлах зохицуулагч өглөө бүр 07:15 цагт бүсийн эргүүлд ажиллаж байгаа алба хаагчдын зам тээврийн ослын дуудлагын шийдвэрлэлт, албаны автомашин хүлээлцэж байгаа байдал, ажлын мэдээнд нь үнэлэлт дүгнэлт өгч, Бямба гариг бүр нэгдсэн журмаар хэлтсийн автомашинуудын техникийн бүрэн бүтэн байдлыг шалган илэрсэн зөрчлийг арилгуулан ажиллаж байна.

Алба хаагчдын бие бялдрыг хөгжүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор алба хаагчдыг хөгжүүлэх өрөөнд штанг, теннисний ширээ байрлуулснаар алба хаагчид ажлын бус цагаар өөрийгөө хөгжүүлэх, спортоор хичээллэх, долоо хоногийн

Мягмар гарагт “Хоршоолол” спорт цогцолборт 21:00 цагаас 23:00 цагийн хооронд сагсан бөмбөг, гар бөмбөг тоглох зэрэг ажлуудыг зохион байгуулж, алба хаагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэн ажиллаж байна.

Хоёр. Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр:

а. Хэрэг бүртгэх албаны чиглэлээр:

Дүүргийн нутаг дэвсгэрт гарсан зам тээврийн осол хэргийн шинжтэй 115 материалыг хүлээн авснаас 55 материалд зөрчлийн хэрэг нээсэн, хялбаршуулсан журмаа 53, үлдэгдэл 2 ослын материалыг хуулийн хугацаанд шалгаж байна.

Зөрчлийн тухай хуулийн 14.7.3.1 дэх заалт зөрчин согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 1238 зөрчлийн материал хүлээж авснаас хялбаршуулсан журмаар 1143 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 1 жилийн хугацаагаар хас ч үлдэгдэл 38 материалыг хялбаршуулсан журмаар болон зөрчлийн хэрэг нээж шийдвэрлэхээр ажиллаж байна.

Зөрчлийн хэрэг нээсэн 170 материалаас зөрчлийн тухай хуулийн 14.7.5 дах заалтын зөрчилтэй 153 иргэнд холбогдох материалыг хүлээн авч 97 иргэнийг шүүхийн шүүгчийн тогтоолоор 7-30 хоног баривчлуулж, зөрчлийн хэрэг үүсгэхээс татгалзсан 0, хэрэгсэхгүй болсон 0, харьяаллын дагуу шилжүүлсэн 0, үлдэгдэл 3 иргэнд холбогдох материалыг хуулийн хугацаанд шалгаж байна.

Зөрчлийн тухай хуулийн 14.7.1 дэх заалтыг зөрчсөн 286 жолоочид холбогдох материалыг хүлээн авснаас хуулийн дагуу торгуулийн арга хэмжээ авагдсан 283, үлдэгдэл 3 материалыг хуулийн хугацаанд нь шалгаж шийдвэрлэж байна.

б. Тээврийн цагдаагийн албаны чиглэлээр:

Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хөтөлбөр, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг ослоос урьдчилан сэргийлэх, гудамж замын хөдөлгөөнд тавих хяналт зохицуулалтыг эрчимжүүлэх, хөдөлгөөнд оролцогчдын сахилга соёлыг дээшлүүлэх чиглэлээр гудамж замд хийсэн хяналт шалгалтаар нийт 74220 зөрчил илрүүлснээс Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн заалт зөрчин согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 1215, мөн хуулийн 14.7 зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчилтэй 296, тээврийн хэрэгслийг түр саатуулан журамлан улсын дугаарын хязгаарлалт 0, бүрэн бус 2803, хамгаалах бүс хэрэглээгүй 11212, хориглосон нөхцөлөөр зогссон 12381, хүн ба ачаа тээвэрлэх журам зөрчсөн 692, эгнээ байр буруу эзэлсэн 3059 нийт 72510 жолоочийг 1.025.731.000 төгрөгөөр торгосон. Тээврийн цагдаагийн алба болон бусад албадаас зарлагдсан 95 дугаарыг илрүүлэн ерөнхий жижүүрт хүлээлгэн өгсөн байна. Цагдаагийн нийтлэг үүргийн дагуу 88, АСАП санд эрэн сурвалжлагдаж байсан 83 иргэнийг илрүүлж харьяаллын дагуу холбогдох байгууллага албан тушаалтанд шилжүүлэн ажилласан. Мөн Цагдаагийн байгууллагаас зохион явуулж буй “Хурд” нэгдсэн арга хэмжээний хүрээнд Зуслангийн замд 2 алба хаагчийг зөөврийн хурд хэмжигчтэйгээр тээврийн хэрэгслийг хурдыг хэмжих шалгалтыг зохион явуулан хурд хэтрүүлсэн 721 зөрчлийг илрүүлж, Нийслэлийн замын хөдөлгөөний удирдлагын төвд шилжүүлэн гэрийн хаягаар бэлэн бус торгуулийг хүргүүлж ажилласан.

в.Цахим зөрчил илрүүлэлт, шийдвэрлэлтийн чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажил:

Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт ЗХД-ийн 11 дүгээр зүйл 11.5 дахь заалтыг зөрчиж зорчих хэсгийн 1 дүгээр эгнээ болон бусад хориглосон газарт зогссон 6336, зохицуулагч, цагдаагийн дэслэгч Л.Тэгшжаргал хуваарьт өдрүүдэд ЗХУТөв дээр ажиллаж дүүргийн нутаг дэвсгэрийн автобусны буудлууд дээр зогссон 254, нийт 6590 зөрчлийг

илрүүлж тээврийн хэрэгслийн гаргасан зөрчлийг фото зургаар баримтжуулан ЗХУТ-д файлаар хүргүүлэн тухайн тээврийн хэрэгслийн эзэмшигчийн гэрийн хаягаар торгуулийн хуудсыг хүргүүлэн ажиллаж байна. Мөн Фото зургийн зөрчил дээр ЗДТГ-аас 3 урамшуулалт эргүүлийг ажиллуулж, ахлах зохицуулагч нар өдөр тутмын үйл ажиллагаанд нь хяналт тавин ажиллаж байна.

г. Нийтийн хэв журам хамгаалах албаны чиглэлээр:

Сүхбаатарын талбай “Мөнгөн шөнө” шинэ жилийн арга хэмжээний үед 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 17:00 цагаас 2019 оны 01 дүгээр сарын 01-ний 01:00 цаг хүртэл талбайн баруун замд болон алсын сийрэгжүүлэлтэд 9 цэгт 10 алба хаагч 2 автомашинтайгаар, 2019 оны 01 сарын 01-ны өглөө зүүн чиглэлд нар харах иргэдийн хөдөлгөөн ихэсдэг Тээврийн цагдаагийн албаны даргын баталсан хуваарийн дагуу тус хэлтсээс 1 автомашинтай 6 алба хаагчийг 03:30 цагаас 13:00 цаг хүртэл Багахангай болон Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт ажиллуулсан бөгөөд зохицуулагч, цагдаагийн ахмад О.Жанчивравдан хариуцаж ажилласан. Жанчин Сүхбаатарын талбайд 2019 оны 01 сарын 10-ны өдөр зохион байгуулагдсан “Манан дэглэмийн эсрэг” тайван жагсаалын үед 6 цэгт 6 алба хаагч, нөөцөд 6 алба хаагч 5 хүн цаг, 2019 оны 01 сарын 16-ны өдөр 1-р чиглэл Улсын ерөнхий прокурорын газар орох буцах үед 4 цэгт 6 алба хаагч 1 хүн цаг, Сар шинийн баярын өдрүүдээр буюу 2019 оны 02 сарын 05-ны өдөр 3-р чиглэл /хуучнаар/ Хүнсний 1-р дэлгүүртэй байранд очих буцах үед 3 цэгт 3 алба хаагч, 2019 оны 02 сарын 07-ны өдөр Гандантэгчлэн хийд очих буцах үед Энхтайваны өргөн чөлөөнд 6 цэгт 6 алба хаагч 1 автомашинтайгаар, Монгол Улсын Их Хурлын дарга 2019 оны 03 дугаар сарын 01-ны өдөр баруун дөрвөн зам очих буцах үед Энхтайваны өргөн чөлөөнд 4 цэгт 6 алба хаагч, Монгол Улсын Их Хурлын дарга, Монгол Улсын ерөнхий сайд нар Санзайн орох буцах үед Зуслангийн замд 4 цэгт 4 алба хаагч, Бүгд Найрамдах Солонгос Улсад гэрээгээр ажиллах хүсэлтэй иргэдийн бүртгэл ерөнхий боловсролын 5 дугаар дунд сургууль дээр зохион байгуулагдсантай холбоотойгоор 2019 оны 03 дугаар сарын 12, 13, 14-ний өдрүүдэд 1 цэгт 2 алба хаагч 1 автомашинтайгаар 48 хүн цаг, Монгол Улсын Ерөнхийлөгч 2019 оны 03 сарын 11-ны өдөр Үлэг гүрвэлийн музей, Байгалийн түүхийн музей, Занабазарын музейгээр ороод буцах үед 16 цэгт 16 алба хаагч, Бүгд найрамдах Солонгос Улсын Ерөнхий сайд Ли Наг Ён тэргүүтэй зочид төлөөлөгчид Манай улсад айлчил хийж байгаатай холбогдуулан 2019 оны 03 сарын 25-ны өдөр “Чингис хаан” Олон улсын нисэх онгоцны буудлаас “Шангри-Ла” зочид буудал орох үед 12 цэгт 17 алба хаагч 3 автомашинтайгаар 4 хүн цаг, 03 сарын 26-ны өдөр “Шангри-Ла” зочид буудлаас UB smart card, Дамбадаржаа дахь Монгол Солонгосын найрамдлын цэцэрлэгт хүрээлэн орох үед 28 цэгт 30 алба хаагч 8 автомашинтайгаар 7 хүн цаг, 2019 оны 03 сарын 27-ны өдөр “Шангри-Ла” зочид буудлаас “Чингис хаан” Олон улсын нисэх онгоцны буудал орох үед 12 цэгт 17 алба хаагч 3 автомашинтайгаар 4 хүн цаг, Иргэн Цэгмидийн ипотекийн зээлийн хүүг бууруулах жагсаалд 2019 оны 04 сарын 1, 2, 3-ны өдрүүдэд 1 цэгт 1 алба хаагч 4 хүн цаг, Жанжин Д.Сүхбаатарын нэрэмжит талбайд “Ардчилсан нам”-аас зохион байгуулсан жагсаал, цуглааны хамгаалалтад 15 цэгт 24 алба хаагч 3 автомашинтайгаар 96 хүн цаг, Монгол Улсын Их Хурлын дарга 2019 оны 04 дугаар сарын 06-ны өдөр МҮЭСТО-руу очиж буцах үед Энхтайваны өргөн чөлөөнд 4 цэгт 6 алба хаагч 1 автомашинтайгаар 18 хүн цаг, 2019 оны 04 дугаар сарын 17-ны өдөр Энхтайваны өргөн чөлөөгөөр явах үед 5 цэгт 5 алба хаагч 5 хүн цаг, Жанжин Д.Сүхбаатарын нэрэмжит талбайд “Ардчилсан нам”-аас зохион байгуулсан жагсаал, цуглааны хамгаалалтад 15 цэгт 24 алба хаагч 3 автомашинтайгаар 96 хүн цаг, Монгол Улсын ерөнхий сайд 2019 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр Байгалийн түүхийн музейруу очиж буцах үеийн хамгаалалтад 2 цэгт 2 алба хаагч 1 автомашинтайгаар, Нийслэлийн нутаг дэвсгэрт гамшгийн болзошгүй гамшиг осол тохиолдсон үед замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах хамгаалалт зохицуулалтын хуваарь төлөвлөгөөний дагуу 2019 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 06:00-09:00 цагийн хооронд замын хөдөлгөөнийг хаах үеийн хамгаалалт зохицуулалтад дүүргийн нутаг

дэвсгэрт 30 цэгт 37 алба хаагч, Чухал амжилт сургалтын төвөөс Тусгаар тогтнолын талбайд 2019 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр сургалтын өдөрлөг болох үеийн хамгаалалтад 1 цэгт 1 алба хаагч, Төвийн бүсийн их хурд хурдан морины уралдааны хамгаалалт зохицуулалтад 2019 оны 05 дугаар сарын 12-ны өдөр 11 алба хаагч 2 автомашинтайгаар 12 цаг, 2019 оны 05 дугаар сарын 14-ний өдөр 2-р чиглэл Авлигатай тэмцэх газар орох буцах үед 4 цэгт 5 алба хаагч, Тээврийн цагдаагийн албаны даргын 2019 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн баталсан “Улаанбаатар марафон-2019” Олон улсын гүйлтийн тэмцээн, “Автомашингүй өдөр” зохион байгуулагдах үед замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, хамгаалалт зохицуулалтад ажиллах хуваарь, төлөвлөгөөний дагуу тус хэлтсийн бие бүрэлдэхүүн дүүргийн нутаг дэвсгэрт 2019 оны 05 сарын 18-ны өглөөний 06:00 цагаас 18:00 цаг хүртэл, Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газраас 7 дахь жилдээ зохион байгуулж байгаа “Бид сайн сайханд дагуулна” уриатай иргэдийн баярын арга хэмжээнд Чингэлтэй дүүрэг дэх замын цагдаагийн хэлтэс оролцож, тухайн арга хэмжээний үеийн замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах хамгаалалт зохицуулалтыг 2019 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 09:00 цагаас 22:00 цагийн хооронд, Төр нийгмийн зүтгэлтэй Г.Батхүү агсан, Сүхбаатар аймгийн Түмэнцогт суманд үүрэг гүйцэтгэж байгаад амь насаа алдсан цагдаагийн алба хаагчийг сүүлчийн замд нь үдэх оршуулгын арга хэмжээний үед Энхтайваны өргөн чөлөөнд 6 цэгт 8 алба хаагч, 1 хөтөч автомашинтайгаар, Монгол Улсын Их Хурлын дарга, Монгол Улсын Ерөнхий сайд Жигжид зуслан явах үед буцах үед 4 цэгт 5 алба хаагч, 1 хөтөч автомашинтайгаар, БНХАУ-ын НАХЯ-ны Өвөр монголын өөртөө засах орны Шиоо Сан тэргүүтэй зочин төлөөлөгчид Монгол улсад айлчлах үед Хан-уул дүүргийн нутаг Яармагийн замд 10 цэгт 12 алба хаагч 5 удаа, зочин ХЗДХЯам орох үед 3цэгт 4 алба хаагчийг тус тус хариуцан замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах хамгаалалт зохицуулалтад ажилласан. Дээрх хамгаалалт зохицуулалтад давхардсан тоогоор 608 алба хаагч 3624 хүн цаг ажилласан.

Гурав. Сахилга хариуцлага, сургалт сурталчилгаа, соён гэгээрүүлэх болон авлигаас урьдчилан сэргийлэх ажлын талаар:

а. Алба хаагчдын сахилга хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээ, түүний үр дүн:

Чингэлтэй дүүрэг дэх замын цагдаагийн хэлтэс нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зам тээврийн осол хэргийг бууруулах чиглэлээр холбогдох хууль, тушаал, шийдвэрүүдийг биелүүлэх, холбогдох хууль, тушаал, шийдвэр, захирамж, цаг үеийн мэдээ мэдээллийг хэлтсийн бие бүрэлдэхүүнд долоо хоног бүрийн Пүрэв гаригийн хэлтсийн хурлаар танилцуулж, долоо хоногийн Даваа гариг бүр хэлтсийн офицеруудын хурлыг зохион байгуулж хэвшээд байна. Алба хаагчдын сахилга хариуцлагыг дээшлүүлэх, сахилга ёс зүйн зөрчил дутагдал гаргахгүй байх үүднээс офицеруудын хурлыг Сахилгын хурал болгож хурлаар алба хаагчдыг оруулж тэдний ажлын амжилт, мөн гарч буй алдаа дутагдлын талаар хэлэлцэн сайн ажиллаж байгаа алба хаагчдыг урамшуулах, ажлын алдаа дутагдал гаргасан алба хаагчдыг дахин зөрчил дутагдал гаргуулахгүй байх талаар анхааруулж ажлын үр дүнг тооцон удирдан зохион байгуулан ажиллаж байна.

Тээврийн цагдаагийн албаны даргын баталсан “Чадварлаг алба хаагч” шалгаруулах удирдамжийн дагуу 2019 оны 03 дугаар сарын “Чадварлаг алба хаагч”-аар зохицуулагч, цагдаагийн дэслэгч Л.Тэгшжаргал, 05 дугаар сарын Чадварлаг алба хаагч”-аар хэрэг бүртгэгч, цагдаагийн ахмад Т.Заяасайхан нар тус тус шалгарсан.

Хэлтсийн дарга, чиглэлийн ахлах зохицуулагч нараас алба хаагч нарт хандан өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой 18 удаагийн зөвлөмж хүргүүлсэн.

Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн А/49 “Цагдаа, дотоодын цэргийн бие бүрэлдэхүүнийг өндөржүүлсэн бэлэн байдлын хоёрдугаар зэрэглэлд шилжүүлэн ажиллуулах тухай”,

Замын цагдаагийн албаны даргын 2018 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн А/08 “Өндөржүүлсэн бэлэн байдлыг хангах, сар шинийн баярын өдрүүдэд хамгаалалт зохицуулалтад ажиллах, хариуцлагатай эргүүл жижүүрийн хуваарийг батлах тухай” тушаалуудыг 2018 оны 02 сарын 03-ний 20:30 цагт алба хаагч нарт танилцуулж тушаалд тусгагдсан зарим нэг үүргийг оруулан хэлтсийн дарга, ахлах зохицуулагч нараас үүрэг аюулгүй ажиллагааны зааварчилгааг өгч гарын үсэг зуруулан баталгаажуулан авсан.

Ахлах зохицуулагч, цагдаагийн ахмад Х.Одбаяр ХСИС-ийн 34 сонсогчид гудамж замд үүрэг гүйцэтгэхдээ өөрийн болон хөдөлгөөнд оролцогчдын аюулгүй байдлыг хэрхэн хангах, биет зохицуулалтыг хэрхэн стандартын дагуу хийх талаар аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгсөн.

“Мотоцикл” нэгдсэн арга хэмжээний үед сайн ажилласан зохицуулагч, цагдаагийн ахмад Б.Сэргэлэнбаатар, О.Жанчивравдан, цагдаагийн дэслэгч Э.Ариунболд, цагдаа зохицуулагч, цагдаагийн ахлах ахлагч Д.Алтан-Эрэг, М.Мөнхбаясгалан, цагдаагийн ахлагч А.Эрдэнэдаваа нарын цалинг 10 хувиар нэмж, хангалтгүй ажилласан ахлах хэрэг бүртгэгч, цагдаагийн дэд хурандаа И.Шагдарсүрэн, мэдээлэл технологийн оператор цагдаа, цагдаагийн дэд ахлагч М.Өнөрцэцэг нарын цалинг 20 хувиар, зохицуулагч, цагдаагийн ахлах дэслэгч Б.Эрхэмбаяр, цагдаа зохицуулагч, цагдаагийн ахлах ахлагч Т.Түвшинбаяр нарын цалинг 5 хувиар, ахлах ахлагч Б.Отгонбаярын цалинг 10 хувиар тус тус хасаж үр дүнг тооцоод байна.

б. Сахилга, ёс зүйн зөрчлийн мэдээ, прокурор, шүүхийн мэдэгдэл, шаардлага:

Ахлах зохицуулагч, цагдаагийн хошууч Ц.Чинзориг хэлтсийн алба хаагчдаас гэмт хэрэг, зөрчилд холбогдсон, өртөж хохирсон талаар Цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн сангаас шүүж дүн мэдээг сар бүрийн 23-ны өдөр Тээврийн цагдаагийн албаны Захиргааны удирдлагын газарт албан тоотоор хүргүүлж хэвшсэн.

Ахлах хэрэг бүртгэгч шинээр томилогдсонтой холбоотойгоор 2019 оны 01 сарын 14-ний өдөр Чингэлтэй дүүргийн прокурорын газрын зөрчил хариуцсан ахлах прокурор А.Алиманцэцэг, Замын цагдаагийн хэлтэс хариуцсан прокуророо Д.Дэлгэрмаа нар өнгөрсөн оны үлдэгдэл хэргийг яаралтай шахаж дуусгах, ахлах хэрэг бүртгэгч, цагдаагийн дэд хурандаа И.Шагдарсүрэнд хийж гүйцэтгэх ажлын зөвлөгөө өгсөн.

в. Алба хаагчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх чиглэлээр дотооддоо зохион байгуулсан сургалт:

Хэлтсийн 2019 оны сургалтын төлөвлөгөөний дагуу “Төрийн албаны тухай хууль”, Тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдал, Эрдэнэс таван толгойн 1072 ширхэг хувьцааг хэрхэн ашиглах талаар, Ачааны тээвэрлэлт, Тээврийн хэрэгсэлд тусгай дуут болон гэрлэн дохио тавьж хэрэглэх журам /MNS4979:2016/, Англи хэлийг хэрхэн хурдан сурах, Архи согтууруулах ундаа түүний хор уршиг, МУ-ын ЗХД-ийн 4 дүгээр хавсралт “Тээврийн хэрэгслийг ашиглахыг хориглох эвдрэл, гэмтэл, техникийн зөрчлийн жагсаалт”-ын талаар, “Биет зохицуулалт”, “Харилцаа хандлага”, “Архи, тамхины хор уршиг, “Эерэг хандлагыг төлөвлүүлбэ”, “Мэдээллийн нууц”, Жижүүрийн шуурхай удирдлагын хэлтсийн техникийн байцаагч цагдаагийн хошууч В.Балжиннямыг урьж “зам тээврийн ослын газрын үзлэгийг хийхэд анхаарах зүйлс”-ийн талаар зэрэг сэдэвт хичээлийг powerpoint дээр бэлтгэж алба хаагчдад ойлгомжтой хүртээмжтэй байдлаар зохион байгуулсан. Нийт 26 удаагийн 50 цагийн сургалтыг ТЦА-ны сэтгэлзүйч цагдаагийн ахмад Э.Бямбажаргал, Техник замын хяналтын хэлтсийн зохицуулагч, цагдаагийн ахлах дэслэгч Б.Энхмөнх, тус хэлтсийн зохицуулагч, цагдаагийн дэслэгч П.Цэрэндорж, цагдаагийн дэслэгч Э.Ариунболд 53-р сургуулийн Англи хэлний багш Х.Энхмаа нар тус тус явуулсан.

Хэлтсийн цагдаа зохицуулагч нарт өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой ЦБҮАЖ-ын холбогдох заалтаар реферат бичүүлэн хураан авч нэгтгэсэн.

г. Төрийн болон төрийн бус байгууллагаас зохион байгуулагдсан сургалт уулзалт, хэлэлцүүлэг, зөвлөгөөнд алба хаагчдыг хамруулсан байдал:

Дүүргийн засаг даргын захирамжийн дагуу дүүргийн орлогч даргаар ахлуулсан Монгол улсын Засгийн газраас 2019 оныг “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил” нийслэлийн төр захиргааны байгууллагаас Иргэдийн оролцоотой хөгжлийн жил, дүүргийн төр захиргааны байгууллагаас Иргэдийнхээ хөгжлийг дэмжих болгон зарласантай холбогдуулан төрийн үйлчилгээг иргэдэд тэгш хүртээмжтэй, түргэн шуурхай, ил тод, нээлттэй хүргэх үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилгоор иргэдийн оролцоог хангаж иргэдийн санал хүсэлтийг сонсож шийдвэрлэх чиглэлээр 3 сарын 29-өөс 04 сарын 06-ны өдөр хүртэл Чингэлтэй дүүргийн 6-р хороонд, 04 сарын 8-аас 04 сарын 15-ны өдөр хүртэл Чингэлтэй дүүргийн 3-р хороонд уг аяны хүрээнд хуваарийн дагуу өглөө 09:00-12:00 цаг, орой 14:00-17:00 цагийн хооронд иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч ажилласан. Чингэлтэй дүүргийн 5-р хороонд уг аяныг эхэлсэнтэй холбогдуулан 04 сарын 16-өөс 4 сарын 23-ны өдөр хүртэл хуваарийн дагуу өглөө 09:00-12:00 цаг, орой 14:00-17:00 цагийн хооронд иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч ажилласан.

Тус хэлтсээс цагдаагийн 1, 2 дугаар хэлтэстэй хамтарч 2018 онд хийж хэрэгжүүлсэн ажлаа дүүргийн иргэдэд тайлагнаж, тэдний санал хүсэлтийг сонсож хийсэн ажилласан.

Тээврийн цагдаагийн албанаас зохион байгуулж байгаа “Бяцхан зорчигч” нэгдсэн арга хэмжээний хүрээнд тус хэлтсээс дүүргийн ГХУСАЗСЗ-тэй хамтран дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй төрийн болон төрийн бус байгууллага, иргэн, аж ахуй нэгж байгууллага, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, эцэг эхийн төлөөллийг оролцуулан хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх “Хүүхдээ хамгаалъя” сэдэвт хэлэлцүүлгийг 2019 оны 05 сарын 28-ны өдөр зохион байгуулж, хэлэлцүүлэгт Чингэлтэй дүүргийн төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгжүүдийн төлөөлөл болсон 160 гаруй иргэн, албан тушаалтан оролцсон. Тус арга хэмжээг MN-25, C-1, Eagle, Tv-6 телевизүүдийн мэдээллийн хөтөлбөрөөр арга хэмжээний талаар болон хэлэлцүүлэг нь хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, эцэг, эх боловсролын байгууллагын үүрэг оролцооны талаар иргэд олон нийтэд мэдээ, мэдээлэл өгсөн.

ЦЕГ-ын Сургалтын нэгдсэн төвөөс зохион байгуулсан төв орон нутгийн ахлах зохицуулагч нарын дунд зохион байгуулсан 2 хоногийн сургалтад чиглэлийн ахлах зохицуулагч, ахлах зохицуулагч нарыг, “Компьютерын хэрэглээний программ, техник хэрэгсэл” сэдвээр 2 хоногийн сургалтад 1 алба хаагчийг, Сургалтын нэгдсэн төвөөс зохион байгуулсан сургагч багшийн сургалтад 1 алба хаагчийг 2019 оны 02 дугаар сарын 25, 27, 28-ны өдрүүдэд, шинээр болон шилжин томилогдсон 2 алба хаагчийг албаны үйл ажиллагаатай холбоотой дадлагажуулах 3 хоногийн сургалтад, “Галт зэвсэг”-ийн сургалтад батлагдсан хуваарийн дагуу алба хаагчдыг, 2019 оны 04 сарын 10, 11, 12-ны өдрүүдэд зохион байгуулсан “Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил” сэдэвт 3 хоногийн модуль сургалтад 1 алба хаагчийг тус тус хамруулсан.

Тээврийн цагдаагийн албанаас зохион байгуулсан 5 хоногийн англи хэлний сургалтад 2 алба хаагчийг, Онцгой байдлын ерөнхий газрын зааланд зохион байгуулсан Авлигын сургалтад 1 алба хаагчийг тус тус хамруулсан.

Дотоод хэргийн их сургуулийн 2019-2020 оны хичээлийн жилд эцнээ 3 жилийн сургалтад хамрагдах зорилгоор 2 алба хаагчийг шалгалт өгүүлсэн.

д. Зохион байгуулсан соён гэгээрүүлэх ажил, арга хэмжээ:

Чингэлтэй дүүргээс зохион байгуулсан “Бид сайн сайханд дагуулна” уриан доор зохион байгуулагдсан Чингэлтэй фестиваль нээлттэй хаалганы өдөрлөгт албанд ашигладаг техник хэрэгсэл болон албаны үйл ажиллагааг сурталчилж иргэд олон нийтэд Цагдаагийн байгууллагаас гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийж хэрэгжүүлж

байгаа ажил, цаашид хийж хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа ажлын талаар иргэд олон нийтэд танилцуулж, зам тээврийн хэрэг ослоос урьдчилан сэргийлэх самбар, албаны техник тусгай хэрэгсэл, мотоцикл, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр бэлтгэсэн гарын авлага, боршур, наалт зэрэг нийт 5 төрлийн 850 ширхэг тараах материал гарын авлагыг иргэдэд тарааж, явуулын постыг танилцуулж ажилласан.

Чингэлтэй дүүргээс сонгогдсон Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэгийн урилгаар 2019 оны 05 дугаар сарын 16-ны өдөр Улсын Их Хурлын үйл ажиллагаатай танилцаж, гишүүн М.Оюунчимэгтэй уулзаж дүүргийн хэмжээнд замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаарх нөхцөл байдал, хийж хэрэгжүүлсэн ажлыг танилцуулж, алба хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн асуудлыг сайжруулах чиглэлээр шаардлагатай техник хэрэгсэл авч ашиглах, алба хаагч нарт зуслангийн газар олгож өгөх асуудлыг дэмжиж хамтран ажиллах зэрэг саналыг хүргүүлсэн.

Тус хэлтсээс “Хувь хүний ёс зүй ба цагдаагийн ажил” илтгэлийн уралдаанд оролцох 3 алба хаагчийн бичсэн илтгэлийг Тээврийн цагдаагийн албанд хүргүүлж, цагдаа зохицуулагч, цагдаагийн дэд ахлагч Д.Хатанбаатар 2-р байранд орсон.

Цагдаа дотоодын цэргийн байгууллагын 2019 оны соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, ЦБҮАЖ код-940 940,2-г хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Гэр бүлдээ бичих чин сэтгэлийн захидал” сэдэвт арга хэмжээний хүрээнд хэлтсийн 5-н алба хаагч захидал бичиж дугуйлж ТЦА хүргүүлж, зохицуулагч, цагдаагийн дэслэгч Б.Мөнх-Эрдэнийн бичсэн захидал шалгарсан.

Соёлч байгууллага хамт олон болон Бяцхан зорчигч аяны хүрээнд Чингэлтэй дүүргийн Улаан загалмайн хороотой хамтарч дүүргийн нутаг дэвсгэрт тээврийн хэрэгслээр хүүхдээ зөв тээвэрлэж байгаа 31 эцэг эх, хүүхдүүдэд 2019 оны 06 дугаар сарын 01-ний өдөр гарын бэлэг олгох ажлыг зохион байгуулж, TV-9, MN25 суваг телевизээр иргэд олон нийтэд хандаж хүүхдээ тээврийн хэрэгслээр .

“ЦЕГ хүч спорт хорооноос зохиогдсон жудо, самбын тэмцээнд цагдаагийн дэд ахлагч Э.Анхбаяр оролцож 2-р байр эзэлж, Тээврийн цагдаагийн албаны “Чадварлаг алба хаагч 2019” цогцолбор тэмцээний хүрээнд зохион байгуулагдсан “Буудлага”, “Боулинг” “Ширээний теннис”, “Дартс”, “Гар бөмбөг”, “Сагсан бөмбөг”, “Унадаг дугуй”, “Шоу интертаймент” зэрэг тэмцээнүүдэд алба хаагч амжилттай оролцуулсан.

е. Хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажилласан байдал:

MN-25 суваг телевизэд “Шинэ жил”-ийн баярын арга хэмжээг байгууллага хамт олноороо тэмдэглэн согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодож замын хөдөлгөөнд оролцохгүй байх талаар, С-1 телевизийн Баярын хөтөлбөрт оролцон хүүхдээ зөв тээвэрлэж, явганы гарцаар зам хөндлөн хөтлөн гарч явсан эцэг, эхчүүдийн 10 хүүхдүүдийг урамшуулан гарын бэлэг өгч албаа болон шинэчлэн батлагдсан замын хөдөлгөөний талаар, MN-25 болон Өлзий телевизүүдэд хамгаалах бүс хэрэглэж хүүхдийг зориулалтын суудалд тээвэрлэж байх талаар, ТВ-9 телевизийн амралтын өдөр гарах “Өглөө” хөтөлбөрийн “Миний өглөө” нэвтрүүлэгт а/ч М.Булганааг оролцуулсан, Монгол HD телевизийн Оргил цаг мэдээллийн хөтөлбөрөөр 10 хүртэлх насны хүүхдийг зориулалтын суудалд суулгаж зөв тээвэрлэх талаар, ETV, SBN, TV-5, Eagle, Star телевизүүдэд Тээврийн цагдаагийн алба, E-mart худалдааны төвтэй хамтран замын хөдөлгөөний дүрмээ биелүүлж хөдөлгөөндөө соёлтой оролцож байгаа 630 жолоочид хүүхдийн хамгаалах бүс тохируулагч тарааж байгаа болон эцэг эхчүүд хүүхдээ зөв тээвэрлэж замын хөдөлгөөндөө оролцохдоо дүрмээ биелүүлж хүүхдэдээ зөв үлгэр дуурайлал үзүүлж байх талаар, Eagle телевизэд чиглэлийн тээврийн хэрэгсэл автобусны буудал дээр зогсож бусад хөдөлгөөнд оролцогчид саад учруулж зам тээврийн осол болох нөхцөлийг бүрдүүлж байгаа талаар, MNC телевизтэй хамтран “Дуудлага” нэвтрүүлэг бэлтгэн замын хөдөлгөөнд оролцож байгаа жолооч эгнээ байр буруу эзлэн бусдын хөдөлгөөнд саад учруулан түгжрэл саатлыг бий болгож байгаа зөрчилд хэрхэн хяналт тавьж хариуцлага тооцдог талаар, С-1 телевизийн “Элсэн цаг” нэвтрүүлгээр оролцон “1 хором хүлээ” аяны

хүрээнд Тээврийн цагдаагийн албанаас хийж хэрэгжүүлж байгаа ажлын талаар, МҮОНРТ, С-1, ТВ-2 телевизүүдэд Гамшгийн үед ажиллах дадлага сургуулилын хүрээнд Тээврийн цагдаагийн албаны бие бүрэлдэхүүн замын хөдөлгөөнийг 07:00-09:30 цагийн хооронд замын хөдөлгөөнийг хааж хамгаалалт зохицуулалт хийж ажиллах талаар, Тв-9 телевизийн "Өглөө" хөтөлбөрийн сурвалжилгаар хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа Д.Ганболд замын хөдөлгөөний нөхцөл байдал, зам тээврийн хэрэг, ослын шалтгаан нөхцөл, хөдөлгөөн зохицуулах журмаар цагдаагийн алба хаагч хэрхэн хяналт шалгалтыг явуулах талаар, МНС телевизийн "Дуудлага" нэвтрүүлгээр ачааны автомашин түүнд тавигдах шаардлагын талаар, Тээврийн цагдаагийн албанаас улсын хэмжээнд зохион байгуулж буй "Бяцхан зорчигч" нэгдсэн арга хэмжээний хүрээнд алба хаагч нар дүүргийн ерөнхий боловсролын сургуулиудтай хамтран хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор иргэд, жолооч нарт санамж, сэрэмжлүүлэг бүхий боршур тараах ажлыг зохион байгуулж, С-1, Тв-9, Өлзий, МНС телевизүүдийн мэдээллийн хөтөлбөрөөр арга хэмжээний талаар болон хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллийг, MN-25 телевизийн 25 Цаг мэдээллийн хөтөлбөрт Цэцэг төв, Цаг уурын уулзварт хийгдсэн шар тэмдэглэгээний хэрэгжилтийг хангах зорилгоор уулзварт камер байрлуулж, камерын хяналтаар илрүүлсэн зөрчлийг тээврийн хэрэгсэл эзэмшигчийн гэрийн хаягаар торгууль ногдуулж байгаа талаар, тус хэлтсээс дүүргийн ГХУСАЗСЗ-тэй хамтран дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй төрийн болон төрийн төрийн бус байгууллага, иргэн, аж ахуй нэгж байгууллага, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, эцэг эхийн төлөөллийг оролцуулан хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх "Хүүхдээ хамгаалъя" сэдэвт хэлэлцүүлгийг 2019 оны 05 сарын 28-ны өдөр зохион байгууллаа. Тус арга хэмжээг MN-25, С-1, Eagle, Тв-6 телевизүүдийн мэдээллийн хөтөлбөрөөр арга хэмжээний талаар болон хэлэлцүүлэг нь хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, эцэг, эх боловсролын байгууллагын үүрэг оролцооны талаар иргэд олон нийтэд мэдээ, мэдээлэл өгсөн. Энэ оны эхний хагас жилийн хэвлэл мэдээллийн байгууллагад 51 удаагийн сэрэмжлүүлэг, мэдээ мэдээллийг иргэд олон нийтэд хүргэн ажилласан байна.

Инээмсэглэл фм-99.3, авто радио 96.3, Kiss фм 100.1-р батлагдсан хуваарийн дагуу хөдөлгөөний ачаалал, замын хөдөлгөөний аюулгүй байдлын нөхцөл байдлын талаар жолооч нарт тогтмол мэдээлэл хүргэн ажилласан. Мөн Тээврийн цагдаагийн албанаас зам тээврийн гэмт, хэрэг ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор "1 хором хүлээ" аяны хүрээнд үүрэн холбооны Мобиком, Скайтел, Юнитейл, Жи мобайл ХХК-уудад "Замын хөдөлгөөнд түрэмгийллээр бус дүрмээрээ оролцъё. Хүлээцтэй хандсан 1 хором ослоос хамгаална." гэсэн өгүүлбэрийг хэрэглэгчдэдээ мессежээр хүргэх ажлыг зохион байгуулсан. Мөн Зам тээврийн гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр бэлтгэсэн 2 төрлийн видео шторкийг С-1, MN-25, TV-8, МНС телевизүүд болон ЧДЗДТГ, Хууль зүйн үндэсний хүрээлэн, Тэнгис кино театр, Барилга хөгжлийн төвийн лед дэлгэцүүдээр иргэд олон нийтэд мэдээ мэдээлэл хүргэн ажиллаж байна.

ё. Техник, замын хяналтын чиглэлээр хийж

гүйцэтгэсэн ажил, арга хэмжээ:

Нийслэлийн автозамын хөгжлийн газар, дүүргийн Засаг даргын тамгын газар, Улаанбаатар зам засварын арчлалтын газартай хамтарч дүүрэг Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэр Энхтайваны өргөн чөлөө, Лааганы гудамж, Бага тойруу, Их тойруу, Зуслан, Дэнжийн мянган зам болон Чингэлтэй дүүргийн 1, 2, 3 дугаар хорооны хорооллын доторх замыг нэг чигийн хөдөлгөөнд оруулсантай холбоотойгоор зам тээврийн хэрэг ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэд жолооч нарт зөв мэдээлэл өгөх зорилгоор 5.19.а.б "явган хүний гарц", 5.23. "Хорооллын эхлэл" 5.24 "Хорооллын төгсгөл", 3.4 "Зам тавьж өг", 3.1 "Гол зам", 5.26 "Чиглэлийн тээврийн хэрэгслийн зогсоол" зэрэг нийт 69 байршилд 94 ширхэг тэмдгүүдийг шинээр болон нөхөн байрлуулсан.

Дүүргийн нутаг дэвсгэрт байрлах ажиллахгүй байгаа гэрэл дохионы судалгааг гаргаж хэвийн ажиллагаанд оруулах 2019 оны 01 сарын 07-ны өдөр 14-2н/11 дугаартай албан тоотоор Замын хөдөлгөөний удирдлагын төвд хүргүүлж хэвийн ажиллагаанд оруулсан.

Сар шинийн баяр"-ын өмнөх амралтын өдрүүдэд Улаанбаатар хотод үүсэх хөдөлгөөний ачааллыг бууруулах зорилгоор Нийслэлийн Засаг даргын 2019 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А/54 тоот захирамж, Тээврийн цагдаагийн албаны даргын баталсан улсын дугаарын хязгаарлалтад ажиллах хуваарийн дагуу дүүргийн нутаг дэвсгэрт амралтын өдрүүдэд буюу 2019 оны 01 дүгээр сарын 26, 27, 02 дугаар сарын 02, 03-ны өдрүүдэд тээврийн хэрэгслийн улсын дугаарын сүүлийн тоог тэгш сондгойгоор хязгаарлан замын хөдөлгөөнд оролцуулах, "Хүчит шонхор" захын зүүн замыг нэг чигийн хөдөлгөөнд оруулж хяналт тавин ажилласан.

Чингэлтэй дүүргийн нутаг Бөмбөгөр худалдааны төвийн урд болон баруун талын, Сангийн яамны зүүн тал, Тэнгис кино театр, Чингэлтэй дүүрэг, Элба төв, Теди төв орчимд байрлуулсан тээврийн хэрэгслийн зорчих хэсгийн хөдөлгөөнийг тусгаарласан 1200 метр хайсыг хөдөлгөөн зохицуулах зорилгоор Сонгинохайрхан дүүрэгт ашиглуулахаар өгсөн.

Улаанбаатар зам засвар арчлалтын газартай хамтарч дүүргийн нутаг дэвсгэрт хазайж мурийсан тэмдгийг тэгшилж, арчилж өнгө үзэмжийг сэргээж ажилласан.

"Тээврийн хэрэгслийн гадна талын гэрэлтүүлэх хэрэгслийн бүрэн бүтэн байдал" хэсэгчилсэн арга хэмжээний хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт хог тээврийн үйл ажиллагаа эрхэлдэг Хот тохижилтын газар, Чингэлтэй дүүргийн ТҮК-ийн 43 тээврийн хэрэгслийг, "Тусгай дуут дохио" хэсэгчилсэн арга хэмжээний хүрээнд Төр захиргааны 3 дугаар бааз, Засгийн газрын авто баазын 41 тээврийн хэрэгслийг, Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт байрлах Улсын ерөнхий прокурорын газрын харъяа авто баазын 40 тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдал болон тусгай дуут дохио хэрэглэж байгаа эсэхэд хяналт шалгалтыг тус тус зохион байгуулж ажилласан.

НАЗХГ, НЗААлбанд дүүргийн нутаг дэвсгэрт байрлах хөдөлгөөн зохицуулах техник хэрэгслийг засварлах талаар 2019 оны 02 дугаар сарын 26-ны өдөр хугацаатай мэдэгдэл хүргүүлсэн.

Самбуугийн гудамжны замын замын хөдөлгөөний ачааллыг бууруулах зорилгоор Теди төвтэй хамтран зүүн хойд талын зогсоолын орц, гарцын хөдөлгөөн зохион байгуулалтыг өөрчилсөн.

Чингэлтэй дүүргийн тохижилт үйлчилгээний компанитай хамтран 140, 117-р сургуулийн авто замын 250 метр хайсыг угааж, Самбуугийн гудамж 850 метр хайсыг будуулж, 12 ширхэг тэмдгийг угаалгаж өнгө үзэмжийг сайжруулж, Голомт банкны картын төвийн урд замд 5.19 явган хүний гарц тэмдгийн гагнаас салсныг засварлуулсан. Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар, Авто тээврийн үндэсний төвтэй хамтран дүүргийн нутаг дэвсгэрт хөдөлгөөнд оролцож байгаа тээврийн хэрэгслүүдийн бүрэн бүтэн байдал, утаа, оношилгоо, иж бүрдэл зэргийг үзэж шалгаж байна. Хяналт шалгалтаар нийт 781 тээврийн хэрэгсэл шалгаснаас зөрчлийн тухай хуулийн 14.7.10.2-т заасны дагуу зөрчилтэй 100 жолоочийг 5.000.000 төгрөгөөр/ таван сая/ торгуулийн арга хэмжээ авч тээврийн хэрэгслийн гэрчилгээг түр хураан авч "Хөсөг трейд" оношилгооны төвд шилжүүлсэн.

Чингэлтэй дүүргийн 1-р хороо 33-р цэцэрлэгийн баруун зам, 5-р хороо Гэсэр сүмийн зүүн талын шороон замуудын явган хүний зам, автомашины зогсоолыг засварлаж шинэчилсэн.

Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас "Нийтэд тустай ажил хийлгэх" ялаар шийтгэгдсэн 7 ялтнаар Баянбүрдийн байнгын пост, хэлтсийн гадна талын цэвэрлэгээ, тохижилт үйлчилгээ болон гудамж замын хөдөлгөөн зохицуулах техник хэрэгсэл, хайс хашлага, тэмдэг тэмдэглэл зэргийг будуулах, угаалгаж цэвэрлүүлэх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгүүлсэн.

Чингэлтэй дүүргийн 5-р хороо Гэсэр сүмийн уулзварын гэрлэн дохионд өөрчлөлт оруулах саналыг Замын хөдөлгөөн зохицуулах хэлтсийн даргад хүргүүлсэн.

Чингэлтэй дүүргийн 5-р хороо Энэбишийн өргөн чөлөө Баянбүрдийн тойргоос Тасганы овооны уулзвар хүртэлх явган хүний зам талбайн засвар шинэчлэлийн ажил хийгдэж байгаатай холбогдуулан хяналт тавин ажиллаж байна.

Улаанбаатар зам засвар арчлалтын газартай хамтарч Чингэлтэй дүүрэг 7, 10 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах 23 ширхэг тэмдгийг угааж цэвэрлэсэн.

Чингэлтэй дүүргийн Тохижилт үйлчилгээний компанитай хамтарч Чингэлтэй дүүргийн 2 дугаар хороо худалдааны гудамж Алтжин худалдааны төвийн урд замын явган хүний 300 метр замыг засварлаж шинэчилсэн.

Нийслэлийн засаг даргын тамгын газар Чингэлтэй дүүргийн Тохижилт үйлчилгээний компанитай хамтарч Чингэлтэй дүүргийн иргэдийн баярын арга хэмжээний хүрээнд Чингэлтэй дүүргийн 4, 5, 6 дугаар хорооны нутаг Анкара, Лааганы гудамж, Нийслэлийн цагдаагийн газрын хойд талын чулуун зам, Тусгаар тогтнолын талбайн замуудыг 2019 оны 05 дугаар сарын 25-ны 00:00 цагаас 22:00 цагийн хооронд нийт 18 уулзвар гарцыг 60 ширхэг усан хаалтаар хааж замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж ажилласан.

ж. Авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээний талаар, түүний үр дүн:

Хэлтсийн долоо хоногийн пүрэв гаригийн хурал дээр ирэх долоо хоногт ажиллах хуваарийг алба хаагчдад танилцуулахдаа авлига, ашиг сонирхлын зөрчилд холбогдохгүй байх талаар зааварчилгаа өгч, гарын үсгээр баталгаажуулан ажиллаж байна. Хэлтсийн алба хаагчдаас 04 дугаар сард авлига, ашиг сонирхлын зөрчилд холбогдоогүй.

Алба хаагчдыг авлигаас урьдчилан сэргийлэх, иргэдэд мэдээлэл хүргэх зорилгоор хэлтсийн байрны 1-р давхрын хүлээлгийн танхимд 1x1.5 хэмжээтэй авлигын тухай хууль, тогтоомжийн танилцуулга бүхий самбар шинээр байрлуулсан.

Онцгой байдлын ерөнхий газрын зааланд зохион байгуулсан Авлигын сургалтад 1 алба хаагчийг 2019 оны 05 дугаар сарын 20-ны өдөр хамруулсан.

Дөрөв. Алба хаагч, ажилтны ажиллах нөхцөл байдал нийгмийн асуудлыг дээшлүүлэх чиглэлээр:

а. Алба хаагчдын ажиллах нөхцөл байдал,

Шинэ жилийн баярыг тохиолдуулан хэлтсийн алба хаагчдын хүүхдийн судалгааг гаргасны дагуу хэлтэс дотооддоо зохион байгуулан 2018 оны 12 сарын 28-ны өдөр алба хаагчдын хүүхдүүдэд нийт 105 бэлэг, Эх үрсийн баярыг тохиолдуулан 2019 оны 05 дугаар сарын 26-ны өдөр хэлтсийн алба хаагчдын гэр бүл, хүүхдүүдийг хүлээн авч Тэнгис кино театрт “Алладин” уран сайхны кино болон Үлэг гүрвэлийн музей үзүүлж, Тусгаар тогтнолын талбай дээр 106 хүүхдэд гарын бэлгийг тус тус тараасан.

Алба хаагчдын 2018 онд ээлжийн амралт авсан талаар судалгаа гаргаж, судалгаанд тулгуурлаж 2019 оны ээлжийн амралтын хуваарийг гаргаж замын цагдаагийн газрын даргаар батлуулсан.

Тус хэлтсээс 2019 онд албан тушаал дэвшүүлэх нөөцөд хамруулах алба хаагчдын материалыг ЗЦА-ны ЗУГ-ын Хүний нөөцийн тасгийн даргад хүргүүлсэн.

Хэлтсийн офицер бүрэлдэхүүний 2018 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг цахим хэлбэрээр мэдүүлж, баталгааны маягтыг хэвлэж гарын үсгээр баталгаажуулсан.

Албанаас шинээр олгосон шалгах төхөөрөмжийг хэлтсийн бүх алба хаагч нарт олгож албаны үйл ажиллагаанд ашиглаж байна.

Чингэлтэй дүүргийн Засаг даргын тамгын газраас 2019 оныг “Иргэдийнхээ хөгжлийг дэмжих жил” болгосонтой холбогдуулж Чингэлтэй дүүрэгт оршин суудаг алба хаагчдын, амины сууцыг 7 сая хүртэлх төгрөгөөр дулаалах, “Монватт” ххк-ний “ЭКО ТУЛГАТ”

цахилгаан зуух суурилуулах хүсэлтэй алба хаагчдын судалгааг Засаг даргын тамгын газарт хүргүүлснээс эхний ээлжид Монгол гэрт амьдардаг цагдаа зохицуулагч, цагдаагийн дэд ахлагч А.Эрдэнэ-Даваа Чингэлтэй дүүргийн Засаг даргын Орлогч Ч.Чимэдцогзолтой уулзаж Монватт” ххк-ний “ЭКО ТУЛГАТ” зуухыг хөнгөлөлттэй авсан.

Хэлтсээс сайн ажиллаж байгаа 2 алба хаагчдыг Чингэлтэй дүүргийн “Хөдөлмөрийн алдар” медалиар шагнуулсан.

Олон нийтийн цагдаа нарын ар гэрийнхэнтэй нь очиж уулзан тэдний санал хүсэлтийг хүлээн авч, амьдрал ахуйтай нь танилцаж, хэлтсээс хийж хэрэгжүүлж байгаа ажлын талаар танилцуулж, 12 төрлийн судалгааг авсан.

Тус хэлтсийн цагдаа зохицуулагч, цагдаагийн ахлагч М.Мөнхбаясгалан, Ц.Пүрэвдорж, Б.Дэлгэрбаяр, Г.Баясгалан, Т.Түвшинбаяр нарын 5 алба хаагч хугацааны ахлах ахлагч цолоор шагнагдсан.

Дотоод хэргийн их сургуулийн 2019-2020 оны хичээлийн жилд эчнээ 3 жилийн сургалтад хамрагдах зорилгоор 2 алба хаагчийг шалгалт өгүүлсэн.

Тус хэлтсээс 3 алба хаагчийг ЦЕГ-н харьяа “Сүүж уулын амралт”-д 5 хоног гэр бүлийн хамт амраасан.

Тээврийн цагдаагийн албанаас ЦЕГ-ын Авто баазтай хамтран албаны автомашины техникийн бүрэн бүтэн байдал, өнгө үзэмжийг шалгах удирдамжит шалгалтад хэлтэст ашиглагддаг 8 автомашиныг шалгуулж, ямар нэгэн зөрчил заагдаагүй.

Хүрэмт-40 постын гадна хайсыг будаж, постын цонх, дээврийг угааж их цэвэрлэгээг хийсэн.

Хэлтсийн цагдаа зохицуулагч нарын амралт чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, тэдний санал хүсэлтийг сонсож цаашид албанд хэрэгжүүлэх зорилгоор 2019 оны 05 дугаар сарын 04-ний өдөр чөлөөт уулзалтыг зохион байгуулсан.

Ардын хувьсгалын болон Цагдаагийн байгууллагын 98 жилийн ойг тохиолдуулан хугацааны цолоор шагнагдах болон ЦЕГ-ын газрын “Хүндэт жуух”-аар шагнагдах алба хаагчдын ажил байдлын тодорхойлолтыг бичиж Хүний нөөцийн тасгийн даргад хүргүүлсэн.

Цагдаа зохицуулагч, цагдаагийн дэд ахлагч Я.Саруул шинэ хүүхэдтэй болсныг тохиолдуулан ахлагч нараас 50,000 төгрөг 1 боодол памперс гардуулсан. Мөн цагдаа зохицуулагч, цагдаагийн ахлах ахлагч С.Алтан-Эрдэнийн төрсөн өдрийг тохиолдуулан ахлагч нараас санаачлан мөнгөн аяга бэлэглэсэн.

Цагдаа зохицуулагч, цагдаагийн ахлагч Б.Мягмарсүрэн Зам тээврийн яамны гэрээт хэлтэст зохицуулагчаар дэвшин томилогдсон.

Тээврийн цагдаагийн албаны 2019 оны 05 дугаар сарын чадварлаг алба хаагчаар хэрэг бүртгэгч, цагдаагийн ахмад Т.Заяасайхан шалгарсан.

б. Эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээ:

Хүйтний улиралд ханиад томуугийн дэгдэлт ихэссэнтэй холбоотой алба хаагчдыг ханиад томуунаас урьдчилан сэргийлэх зорилгоор халуун аарц болон хүчил төрөгчийн коктейлийг уулгах ажлыг зохион байгуулсан.

Алба хаагчдын нойргүйдлийн судалгааг гаргаж эмчилгээнд хамруулахаар ТЦА-нд нэрсийг хүргүүлсэн.

Тус хэлтэст шинээр томилогдоод элэгний ВС вирусийн шинжилгээнд хамрагдаагүй байсан алба хаагчдыг нөхөж хамруулсан.

Эрүүл цагдаа хөтөлбөрийн хүрээнд 2019 оны 05 дугаар сарын 18-ны өдөр Евростандарт лабораторитой хамтран хэлтсийн алба хаагчаас биохимийн шинжилгээг цус, шээсээр өгүүлж, шинжилгээний хариуг Тээврийн цагдаагийн албан дээр зохион байгуулсан эмч нарын нэгдсэн үзлэгт алба хаагчдыг бүрэн хамруулсан. Үзлэгээр урьдчилан сэргийлэх үзлэгээр хэвлийн ЭХО-гоор элэг, цөс, нойр булчирхай, дэлүү, бөөрний өөрчлөлт, зүрх судасны эмчийн үзлэгээр зүрхний цахилгаан бичлэг хийж зүрхний хэм алдалт, зүрхний цусан хангамжийн дутагдал, зүрхний шигдээс өвчин, чих хамар

хоолойн эмчийн үзлэг хийж алба хаагч бүрт эрүүл мэндийн зөвлөгөө өгч шаардлагатай эм, эмчилгээг бичиж өгсөн.

Эрүүл цагдаа хөтөлбөрийн хүрээнд “DIGITAL DENT” шүдний эмнэлэгтэй хамтран 2018 оны 11 сарын 19-ний өдрөөс эхлэн хэлтсийн алба хаагчдын амны хөндийн эрүүл мэндийн үзлэгийг үнэ төлбөргүй зохион явуулснаас хойш он гараад 5 шатны үзлэгт 27 алба хаагч хамрагдаж, шаардлагатай эмчилгээ үйлчилгээг хийлгээд байна.

“Монголын эрдэст ус технологи хөгжлийн компани” ХХК-тай хамтарч 2019 оны 06 дугаар сарын 06-ны өдөр алба хаагчдын дунд ус уухын ач тус, хэрхэн эрүүл зөв хооллох талаар 1 цагийн сургалтыг зохион байгуулж, сургалтыг “Consumer education center” сургалтын төвийн сургагч багш, химич биологич н.Отгонзул орсон. Дээрх байгууллагаас 80.000 төгрөгийн үнэ бүхий усыг эрдэсжүүлэгч төхөөрөмжийг хөнгөлөлттэй нөхцөлөөр авах саналыг тавьсаны дагуу 29 алба хаагчид ус эрдэсжүүлэгчийг авсан байна.

Алба хаагчдын бие бялдрыг хөгжүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор алба хаагчдыг хөгжүүлэх өрөөнд дартс, теннисний ширээ байрлуулснаар алба хаагчид ажлын бус цагаар өөрийгөө хөгжүүлэх, спортоор хичээллэх, долоо хоногийн Мягмар гаригт “Хоршоолол” спорт зааланд 21:00 цагаас 23:00 цагийн хооронд сагсан бөмбөг, гар бөмбөг тоглох зэрэг ажлуудыг зохион байгуулж, алба хаагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэн ажиллаж байна.

Голден жем фитнес клубтэй хамтарч хэлтсийн алба хаагчдыг 50 хувь хөнгөлөлттэй үнээр хамруулах ажлыг зохион байгуулж, хэлтсээс 5 алба хаагч фитнесээр хичээллэж байна.

в. Байгууллагын аюулгүй байдлыг хангах чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээ:

Мөн хэлтсийн байрны угтах үйлчилгээнд 08:00 цагаас 15:00 цагийн хооронд Олон нийтийн цагдааг, 15:00 цагаас 08:00 цаг хүртэл хэлтсийн алба хаагчдыг ажиллуулж байна. Хэлтсийн байранд жижүүрээр ажиллаж байгаа алба хаагчид, алба хаагчдын цагийн бүртгэл, гадуур явсан бүртгэл, лацны бүртгэл, эд аж ахуй хүлээлцсэн бүртгэлийг тус тус хөтөлж хэвшсэн бөгөөд хоногийн хугацаанд хэрхэн ажилласан талаарх рапортыг бичиж өглөө бүр ахлах зохицуулагч нар биечлэн танилцаж хяналт тавин ажиллаж байна.

Барилга байгууламжийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр 2019 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 14-24/184 дугаартай албан тоотоор Нийслэлийн мэргэжлийн хяналтын газарт хэлтсийн байранд улсын байцаагчийн дүгнэлт гаргуулах хүсэлтийг хүргүүлсний дагуу 2019 оны 05 дугаар сарын 28, 06 дугаар сарын 03-ны өдрүүдэд мэргэжлийн хяналтын байцаагч н.Содномпил дүгнэлт гаргах үүднээс хэлтсийн байранд үзлэг, шалгалт хийгээд байна

Тав. Дотоод хяналтын хүрээнд:

а. Байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийсэн байдал:

Алба хаагчдын ажлын тайланг гаргаж ЦБҮАЖ /код-110/-ийн дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж үр дүнг сар бүрийн 23-ны өдөр тооцон ажиллаж.

б. Хяналт шалгалт, албаны шалгалтын талаар:

Хэлтсийн дарга, чиглэлийн ахлах зохицуулагч, ахлах зохицуулагч нар дотооддоо алба хаагчдын өдөр тутмын үйл ажиллагаанд тавих хяналт шалгалтыг тогтмол зохион явуулж байна.

Ёс журмын эргүүлээр зөрчил заагдсан хэрэг бүртгэгч Ж.Энхтайван, олон нийтийн цагдаа Д.Мөнхдэлгэр нар ТЦА-ны ЗЦГ-н даргаас өгсөн үүргийн дагуу сануулах арга хэмжээ авагдсан.

Зургаа. Дүгнэлт:

Тээврийн цагдаагийн албанаас зохион байгуулж байгаа "Бяцхан зорчигч" нэгдсэн арга хэмжээний хүрээнд тус хэлтсээс дүүргийн ГХУСАЗСЗ-тэй хамтран дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй төрийн болон төрийн бус байгууллага, иргэн, аж ахуй нэгж байгууллага, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, эцэг эхийн төлөөллийг оролцуулан хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх "Хүүхдээ хамгаалъя" сэдэвт хэлэлцүүлгийг 2019 оны 05 сарын 28-ны өдөр зохион байгуулснаар хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагын дуу хоолой, санал хүсэлтийг сонсож, цаашид энэ хүүхдийг зам тээврийн осолд өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр хийж хэрэгжүүлэх ажлыг тодорхой үе шаттайгаар зохион байгуулахаар болсон.

ТАЙЛАН БИЧСЭН:

ЗОХИЦУУЛАГЧ,
ЦАГДААГИЙН АХМАД

Б.АЛТАНДӨШ

ХЯНАСАН:

АХЛАХ ЗОХИЦУУЛАГЧ,
ЦАГДААГИЙН АХМАД

Х.ОДБЛЯР

ТАНИЛЦСАН:

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

О.Д. ГАНБОЛД

